



**НИЙСЛЭЛИЙН  
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 04 сарын 09 өдөр

Дугаар A/85

Улаанбаатар хот

**Хөдөлмөрийн дотоод журам  
шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.3 дахь хэсэг, Хөдөлмөрийн тухай хуулийн 130 дугаар зүйл, “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрэм”-ийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын нийт албан хаагчдын хөдөлмөрийн дотоод харилцааг зохицуулах “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын хөдөлмөрийн дотоод журам”-ыг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Шинэчлэн батлагдсан журмыг 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөхийг нийт албан хаагчдад, мэдээлэн танилцуулах ажлыг хийж гүйцэтгэхийг Захиргаа, санхүүгийн хэлтэст үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч дарга (Б.Болор-Эрдэнэ)-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан газрын даргын “Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай” 2019 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн А/170 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  М.БАЯРАА

  
1119282498 ± 2578889

Тушаал2021

115050000135